



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 81745

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Өгөөмөр 2 дугаар гудамж 230 тоотын зүүн талд 793м² газрыг Н.Алтангэрэл (ЙЮ77070776)-д гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, 5 дугаар баг Ренчинпэлжээгийг гудамж 115 тоотын урд Ө.Жандүдсансум (ЙП77070412)-д амины орон сууцны зориулалтаар 121м² газрыг 15 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101624

D:My Doc. Zahiramj. Zasag darga